



УДИРДАМЖ

2024 оны 11 дүгээр сарын 04

Эрдэнэбулган сум

Соёлын төвүүдэд дотоод хяналт,
шалгалт хийх ажлын тухай

Нэг. Дотоод хяналт хийх үндэслэл:

Соёлын тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам болон Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/05 тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Зорилго:

Соёлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" болон бусад мөрдөгдөж буй хууль журмын хүрээнд дотоод хяналт шалгалт хийх мөн 2023 - 2024 оны зөвлөмжийн хэрэгжилтийг үзэж, тухайн байгууллагаас илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах.

Гурав. Хамрах хүрээ:

Соёл, урлагийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/01 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу 18 сумын Соёлын төвийн 2023 - 2024 оны үйл ажиллагааг хамруулж дараах чиглэлээр дотоод хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хугацаа:

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн
Хяналт - шинжилгээ, үнэлгээ дотоод хяналт,
статистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Архивч - бичиг хэрэг, нярав

Д.АВАРЗАД

Б.БАТСҮХ

Т.ХОНГОРЗУЛ
Д.САРАНГЭРЭЛ

Хугацаа: 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд

Тав: Ажлын хэсгийн хүрээнд:

- 2023 - 2024 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг үзэх;

- Байгууллагын гаргасан шийдвэр, албан бичгийн хэрэгжилт, архивын хадгалалт, хамгаалалтыг үзэх;
- Ажилчдын албан хаагчдын хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг үзэх;
- Суурь санхүүжилт, орлого бүрдүүлэлт, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн баримт материалыг үзэх 2023 - 2024 он;
- Хандив тусламжаар ирсэн хөрөнгийн бүртгэл мэдээлэл;
- Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлжүүлэлтийг үзэх;
- 2023 - 2024 оны аудитын дүгнэлт, зөвлөмжийн талаар авч хэрэгжүүлсэн ажил;
- Статистик мэдээний үнэн зөв тайлагналт, хугацаандаа ирүүлж ажиллаж байгаа эсэх
- Архив, албан хэрэг хөтлөлтийг үзэх;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилт;
- Орон нутаг судлах танхимын үзүүлэг дэглэлт;
- Соёлын өвийн хадгалалт хамгаалалт, бүртгэн баримтжуулалт;
- Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээлэл, шавь сургалт түгээн дэлгэрүүлэлт;

Зургаа. Тайлан ба хүрэх үр дүнгийн талаар:

Дотоод хяналтын талаар байгууллагын удирдлага, ажилтнуудад танилцуулж дүнгийн хурал хийнэ.

Соёлын төвд дотоод хяналт хийсэн ажлын тайланг нэгтгэн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын даргад танилцуулна.

Соёлын төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажил хийгдсэнээр зөрчил дутагдлыг арилгах, төсвийн хяналтыг сайжруулах, Соёлын тухай хууль, Соёлын өвийн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Төсвийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах, эргэх холбоог сайжруулах, сахилга хариуцлагыг чангатгах, соёлын салбарын бодлогын хүрээнд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР

СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗӨВЛӨН ТУСЛАХ АЖЛЫН ТАЙЛАН

1. ЗОРИЛГО:

Соёлын тухай хууль, Соёлын өвийн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Төсвийн тухай хууль, Архивын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах, Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/05 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам", Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/01 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зорилгоор дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлж ажиллалаа.

2024 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын удирдамжаар батлагдсан соёлын байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлын удирдамжид тусгагдсан ажил, арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэн ажилласан.

2. ХАМАРСАН ХҮРЭЭ:

Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/01 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу ажиллах удирдамж батлуулан дотоод хяналт, шалгалтын ажлын хэсэг удирдамжид заасан ажил үүргийн дагуу 2024 оны сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлт, 2024 байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, байгууллагын гаргасан шийдвэр, албан бичгийн хэрэгжилт, архивын хадгалалт хамгаалалт, ажилчдын албан хаагчдын хувийн хэрэг, тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, Соёлын төвийн өөрийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, орон нутагт удаан жил ажилласны тэтгэмж болон бусад санхүүгийн баримт, хандив тусламжаар ирсэн хөрөнгийн бүртгэл мэдээлэл, 2023 оны аудитын дүгнэлт, зөвлөмжийг үзэх, статистик мэдээний үнэн зөв байдал, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, орон нутаг судлах танхимын үзүүлэг дэглэлт, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, бүртгэн баримтжуулалт, соёлын биет бус өвийн бүртгэл мэдээлэл, шавь сургалт түгээн дэлгэрүүлэлт болон ил тод байдал зэргийг хамруулсан болно.

3. АРГА ЗҮЙ:

Сумын соёлын төвийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслахыг хэрэгжүүлж ажиллахдаа удирдамжид заасан хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн актын хүрээнд тухайн Соёлын төвийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй баримт бичиг, өөрийн орлогын бүрдүүлэлт, төсвийн төлөвлөлт, тайлагналт, бусад мөрдөгдөж буй журмуудын хүрээнд:

- ✓ Түүвэрлэн үзэх
- ✓ Тулган баталгаажуулах
- ✓ Арга зүйн зөвлөмж өгөх чиглэлээр хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийлээ.

Соёлын төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэхэд удирдамж боловсруулан батлуулж, хууль тогтоомж, эрх зүйн хүрээнд дотоод хяналтын зарчим, аргачлалыг баримтлан төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, аймаг дахь Төрийн аудитын газар, Санхүү аудитын алба зэрэг эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн албан шаардлага, зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилт, өөрийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, соёлын үйлчилгээ, өв соёлын бүртгэл мэдээлэл, шавь сургалт зохион байгуулсан эсэх, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хүний нөөцийн бүрдүүлэлт зэргийг онцлон үзэж зөвлөмж өгсөн.

4. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ, ДОТООД ХЯНАЛТ ЯВУУЛСАН ТАЛААР:

Газрын дарга, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Төсөв хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтэн, Төлөвлөлт, тайлагналт, цахимжилтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хяналт - шинжилгээ, үнэлгээ дотоод хяналт, статистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Архивч - бичиг хэрэг, нярав нар дотоод хяналт шалгалт зөвлөн туслах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/01 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу 13 сумын Соёлын төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж тайлан, зөвлөмжийг тухайн сумын соёлын төвд хүргүүлсэн.

5. ДОТООД ХЯНАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ТАЛААР:

- Төрийн албаны салбар зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. (албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл дутуу).
- Өөрийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавьдаггүй, тасалбар болон бүртгэл хөтөлт байхгүй архивын нэгж үүсгээгүй ажиллаж байна.
- Төлбөрийн хүсэлт, баримтыг нөхөн бүрдүүлдэг.
- Анхан шатны баримт бичиг эмх цэгцгүй байна.
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-г зөрчиж зардлыг зориулалтын бус зарцуулсан.
- Архив, албан хэрэг хөтлөлттэй танилцахад стандарт хангалтгүй, даргын тушаал, ирсэн, явуулсан албан бичиг бүртгэл хөтлөөгүй, өмнөх оны архивын баримтыг эмхлэн цэгцлээгүй байгаа нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаалын хавсралт "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.
- Соёлын биет болон биет бус өвийн бүртгэл мэдээлэл дутмаг зэрэг нийтлэг алдаа зөрчил илэрлээ.

6. ДҮГНЭЛТ:


6.1 Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/05 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам", Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/01 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу Соёлын төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийхэд ажлын ачаалал хэвийн зарим сумын орон тооны хувьд дутмаг соёлын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн актын хүрээнд ажиллаж байгаа боловч зарим алдаа дутагдал илэрч байгаа нь цаашид санхүү төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, архив албан хэрэг хөтлөлт, соёлын үйл ажиллагааг сайжруулах холбогдох албан хаагчдаа сургалтад хамруулах, шаардлагатай байна.

6.2 Сумын соёлын төвүүдэд гарсан зөрчил дутагдлууд харилцан адилгүй ялгаатай байсан бөгөөд хяналт хийсэн байгууллагад тухай бүрд зөвлөмж өгч, хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтийн хангаж ажиллах талаар үүрэг чиглэл өгч дотоод хяналт, зөвлөн туслах ажлын тайланг Соёлын төвийн дарга нарт албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас дотоод хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулдаггүй тул жил тутамд хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж хамтран ажиллаж, Соёлын төвийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Тайлангийн баталгаажуулалт:

Танилцсан: Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын дарга  Н.Сэр-Од

Тайлан бичсэн: Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн  Б.Батсүх

